

“Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн” ТӨҮГ-ын  
захирлын 2017 оны 06 сарын 05 өдрийн  
А/20 тоот тушаалын нэгдүгээр хавсралт



## ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ҮНЭ ТООЦОХ ЖУРАМ

### Ерөнхий үндэслэл

Монгол Улсын "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай" хууль, Эрчим хүчний сайдын 2012 оны 64 тоот тушаал, 2017 оны 50 тоот тушаалуудын дагуу тусгай зөвшөөрөл олгоход урьдчилсан дүгнэлт гаргахтай холбогдон гарах зардал, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбоотой асуудлаар мэргэжлийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс тавьсан санал, хүсэлтийн дагуу дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээний үүргийг хэрэгжүүлэх ажлыг хийж биелэлтэд үнэлэлт өгөх, чадварын болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны хяналт тавих, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, техникийн асуудлыг шийдвэрлүүлэх, маргаан гомдлыг арилгах тэдгээрийн үйл ажиллагааны талаар тодорхойлолт, санал гарган асуудлыг хурлаар оруулж шийдвэрлүүлэх зэрэгтэй холбоотой зардлыг тооцсон зөвшөөрөл олгох үйлчилгээний үнийг тогтооход энэхүү журмын зорилго оршино.

### Нэг. Нэр томъёо

1.1 "Суурь үнэ" гэж тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаатай холбогдох материалтай танилцан эхний шатны дүгнэлт гаргах зардал буюу урьдчилсан дүгнэлт гаргах комиссын гишүүд, ажлын албаны цалин, хөлс болон бусад бараа, үйлчилгээний зардалд суурилагдсан дүн

1.2 "Үндсэн нэр төрлийн ажлын үнэ" /тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн ажил, ажилбарын жагсаалт/ гэж зөвшөөрөл олгосны дараа үеийн зардал буюу тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй холбоотой асуудлаар мэргэжлийн болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс тавьсан санал, хүсэлтийн дагуу дүгнэлт гаргаж шийдвэрлүүлэх, тусгай зөвшөөрөл эзэмшигчидтэй байгуулсан гэрээний үүргийн биелэлт, чадварын болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаанд хяналт тавих, мэргэжлийн туслалцаа үзүүлэх, техникийн асуудлыг шийдвэрлүүлэх, маргаан гомдлыг арилгах тэдгээрийн үйл ажиллагааны талаар тодорхойлолт, санал гарган хэвийн үйл ажиллагааг нь хангахад чиглэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлэхэд тусгай зөвшөөрөл олгогчийн үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх зорилгоор тогтоосон үнийг тус тус хэлнэ.

### Хоёр. Тусгай зөвшөөрөл олголттой холбогдон гарах үйлчилгээний үнэ төлөх

2.1 Тусгай зөвшөөрлийн үйлчилгээний хөлс нь суурь үнэ, үндсэн нэр төрлийн ажлын үнийн нийлбэрээс бүрдэнэ.

2.2 Тусгай зөвшөөрөл хүсэгч холбогдох материалыг журмын дагуу бүрдүүлж, суурь үнийг нь төлсөн баримтын хамт тусгай зөвшөөрөл олгогчид ирүүлнэ.

2.3 Тусгай зөвшөөрлийн комиссын хурлаар холбогдох асуудал хэлэлцэгдэн комиссын шийдвэр гарсны дараа үндсэн нэр төрлийн ажлын үнийг төлнө.

### Гурав. Тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үнийн хэмжээ

3.1 Тусгай зөвшөөрөл олгох үндсэн нэр төрлийн суурь үнэ 100000 төгрөг (нэг зуун мянга) байна.

3.2 Шинээр тусгай зөвшөөрөл авах эрчим хүчний байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, зураг төсөл боловсруулах, эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах /сэргээгдэх/, цахилгаан дамжуулах шугам, дэд станц, зуух, даралтат сав, шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засварын ажил, туршилт тохируулга, бусад дагалдах ажил үйлчилгээ эрхлэх, хуулийн этгээд болон бусад тусгай зөвшөөрөл олгох үйлчилгээний үндсэн нэр төрлийн үнэ /Тусгай зөвшөөрөл олгогдсоны дараа ажилбарын үнийг төлнө./

Категори Код	Ажилбарууд	Хураамж жил
<b>03.1 Эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах</b>		
03.1.1	0.1-5МВТ-ын хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	200,000₮
03.1.2	0.1-100МВТ-ын хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	400,000₮ 1 МВт тутамд 20,000₮ нэмнэ.
03.1.3	0.1-100МВТ, түүнээс дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэр барих, угсрах, засварлах, туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	800000₮ 1МВт тутамд 40,000₮ нэмнэ.
<b>33.2 Цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар</b>		
03.2.1	0.4-10кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	200,000₮
03.2.2	0.4-15кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	400,000₮
03.2.3	0.4-35кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	600,000₮
03.2.4	0.4-110кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	1,200,000₮
03.2.5	0.4-220кВ, түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	2,400,000₮
<b>03.3 Зуухны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ</b>		
03.3.1	0.7-16.0кгх/см <sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	200,000₮
03.3.2	0.7-40кгх/см <sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	400,000₮

03.3.3	0.7-80кгх/см <sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	800,000₮
03.3.4	0.7-160 кгх/см <sup>2</sup> даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	1,600,000₮
03.3.5	0.7-160 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралттай зуухны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил	2,000,000
<b>03.4 Даралтад савны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ</b>		
03.4.1	0.7-16.0кгх/см <sup>2</sup> даралттай даралтад савны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	200,000₮
03.4.2	0.7-40кгх/см <sup>2</sup> даралттай даралтад савны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	400,000₮
03.4.3	0.7-80кгх/см <sup>2</sup> даралттай даралтад савны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	800,000₮
03.4.4	0.7-80 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралттай даралтад савны угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	1,600,000₮
<b>03.5 Шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ</b>		
03.5.1	0.7-16.0 кгх/см <sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	200,000₮
03.5.2	0.7-40 кгх/см <sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	400,000₮
03.5.3	0.7-80 кгх/см <sup>2</sup> даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	800,000₮
03.5.4	0.7-80 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралттай дулааны шугам хоолой, дулаан дамжуулах төвийн угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	1,600,000₮
<b>3.6 Туршилт тохируулгын ажил үйлчилгээ /горим тохируулга, хэмжилт туршилт, хоёрдогч хэлхээний ажлууд/</b>		
03.6	Туршилт тохируулгын ажил үйлчилгээ/горим тохируулга, хэмжилт туршилт, хоёрдогч хэлхээний ажлууд/	200,000₮
<b>03.8 Даралтанд ажилладаг тоноглолуудын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ</b>		
03.8.1	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> даралтанд ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	400,000₮

03.8.2	0.7-40.0кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралтанд ажилладаг тоноглолын угсралт, засвар, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ	800,000₮
<b>03.9 Эрчим хүчний байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах</b>		
03.9.1	100 МВТ хүртэл хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	100,000₮
03.9.2	0.1-100 МВТ-аас дээш хүчин чадалтай эрчим хүчний эх үүсвэрийн ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах	200,000₮
03.9.3	0.4-110 кВ-ын хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг, төсөл боловсруулах	100,000₮
03.9.4	0.4-110 кВ, түүнээс дээш хүчдэлтэй цахилгаан дамжуулах шугам, дэд станцын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	200,000₮
03.9.5	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> даралттай зуухны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	100,000₮
03.9.6	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралттай зуухны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	200,000₮
03.9.7	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> даралттай даралтат савны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	100,000₮
03.9.8	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралттай даралтат савны ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	200,000₮
03.9.9	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> даралттай шугам хоолой, дулаан дамжуулах төвийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	100,000₮
03.9.10	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралттай шугам хоолой, дулаан дамжуулах төвийн ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	200,000₮
03.9.11	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> даралтанд ажилладаг тоноглолын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	100,000₮
03.9.12	0.7-40.0 кгх/см <sup>2</sup> , түүнээс дээш даралтанд ажилладаг тоноглолын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах	200,000₮

3.3 Шинээр тусгай зөвшөөрөл хүсэгч үндсэн нэр төрлийн ажлын хэд хэдэн бүлгийн ажилд тусгай зөвшөөрлийг нэг мөр авах бол суурь үнийг бүлгийн тоог харгалзахгүй нэг удаа төлнө.

3.4 Тусгай зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрөл авснаас өөр үндсэн бүлгийн ажилд тусгай зөвшөөрөл авах бол шинээр авах үндсэн нэр төрлийн ажилбар бүрийн үнийг суурь үнийн хамт төлнө.

3.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрлийн эрхийн бичгийг санамсаргүйгээр үрэгдүүлснээ хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан хүчингүй болгосон тохиолдолд гэрчилгээг шинээр авахдаа суурь үнийг төлнө.

3.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигч тусгай зөвшөөрөлтэй үндсэн нэр төрлийн бүлэгт нэмэлт ажилбар авах нөхцөлд ажилбарын үнийг төлнө.

3.7 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үндсэн үйл ажиллагаа өөрчлөгдөөгүй боловч нэр өөрчлөгдсөн тохиолдолд суурь үнийг төлнө.